


# Хүний Хөгжлийн Илтгэл 2020



Шинэ эрин:  
Хүний хөгжил ба Антропоцений үе



Товч хураангуй бичвэр

## 2020 оны Хүний Хөгжлийн Илтгэл

### “Шинэ эрин: Хүний Хөгжил ба Антропоцений үе”

#### **Товч хураангуй**

Шинэ төрлийн коронавирус нь бидний нийгмийн суурь доголдлуудыг ил болгохын зэрэгцээ бүхий л салбарт бий болсон тэгш бус байдлыг тархсан газар бүртээ гүнзгийрүүлж байна. Бид байгальтайгаа дур зоргоор харьцахаа болиогүй байгаа цагт энэ мэт хямралуудтай учирсаар байх юм.

Хүмүүс хийгээд дэлхий гараг **Антропоцен буюу Хүн төрөлхтөн эх дэлхийгээ өөрчилж буй үе** гэх геологийн тооллын цоо шинэ эрин үед шилжиж байгаа энэ цагт баян, ядуу гэлтгүй бүхий л улс орон, байгаль дэлхийдээ учруулж буй ноцтой хохирол, үр дагавраа бүрэн тооцож хүний хөгжлийн загвараа шинээр зураглах цаг иржээ.

Энэ шаардлагын үүднээс Хүний Хөгжлийн Илтгэлийн 30 жилийн ойг тохиолдуулан гаргасан “Шинэ эрин: Хүний хөгжил ба Антропоцений үе” илтгэлд жил тутмын Хүний хөгжлийн индексэд (ХХИ) туршилтаар шинэ хэмжүүр нэмсэн байна. Үүний дүнд хүний хөгжилд хүрэх зардал-үр дүнгийн тооцоог илүү бодитоор шинжлэх боломж бүрдэж байна.

**Хүний хөгжлийн өндөр түвшинд хүрсэн ч байгаль дэлхийдээ бага дарамт учруулсан байх гэсэн тэрхүү шидэт хослолыг хангасан улс орон дэлхий дээр хараахан алга байна.**

Антропоцений үеийг хүн төрөлхтөн даван туулж, хөгжин цэцэглэхийн тулд **байгаль дэлхийдээ учруулж буй дарамтаа бууруулах шаардлагатай** энэ цаг үед туршилтын шинэ индексээр дэлхийн улс орнуудыг эрэмбэлсэн дүрслэлд дээр дурьдсан шидэт хослолыг харуулсан хэсэг одоогоор хоосон байна.

Гэвч түүнийг дүүргэх боломжтой. **Тэрхүү хоосон орон зайг дүүргэх нь бидний сонголтын асуудал юм.** Үүний тулд эхлээд **байгалийн болон нийгмийн тэнцвэрт байдал харилцан хамааралтай** байж, бие биедээ нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрөх **шаардлагатай.**

Тэгш бус байдал нь **байгалийн гамшигт үзэгдлийн харилцан адилгүй үр дагавраас** үүдэн илэрдэгээс гадна шийдэлд хүрэх замд байгаа **эрх мэдлийн тэнцвэргүй нөхцөл ба нөөц боломжийн ялгаатай байдлаас** давхар шалтгаалж байна.

КОВИД-19-ийн вакцины талаар нааштай мэдээ гарч эхэлсэн тул дэлхий ертөнц удахгүй цар тахлыг даван туулах боломжтой болно. Гэхдээ “хуучин амьдралын хэв маяг”- даа эргэн орж болохгүй. Нэгэнт тогтсон арга барилаараа үргэлжлүүлэх боломжгүй юм. **Хүн төрөлхтөн өөрчлөлтийг сонгох, нэг эрин үед нэг л тохиох ховорхон боломж** бидэнд байна.

**Сонголт ба эрх чөлөөг өргөжүүлэхийг** чухалчилсан хүний хөгжил нь хүмүүс хийгээд байгаль дэлхийд маань цааш явах замыг нээн өгч байна.

### **Зорилго**

Нийгмийн болон байгалийн тогтолцоог бэхжүүлж, хүмүүс хийгээд байгаль дэлхий хамтдаа цэцэглэн хөгжих тийм өөрчлөлтийг авчрах энэхүү боломжийг ашиглах;

“Эх дэлхийгээ хохироохгүй”-гээр хүний хөгжлийн өндөр түвшинд хүрэхэд нь бүх улс оронд туслах

### **Сорилт**

2020 он гараг дэлхийд маань ч, хүмүүст ч ихээхэн хор хохиролтой он байлаа. Атлантын хар салхи; Австрали, АНУ, Сибирь, Бразилд дэгдсэн асар том ой хээрийн түймэр; олон сая хүн амиа алдаж, илүү олон сая хүн ажиллах, сурах, хайртай дотны хүмүүстэйгээ уулзах боломжоо алдсан цар тахал гээд **байгаль болон нийгмээс анхааруулсан улаан дохио тогтмол анивчсан** он байв.

Гэвч эдгээр нь 2020 онд гэнэтийн эсвэл санамсаргүй зүйлс биш юм.

Эрдэмтэд цаг агаарын онц аюулт үзэгдэл болон байгалиас хүнд тархах вирусийн цар тахал дэгдэх эрсдэлийг олон жил таамагласан. Энэ бүхэн хүн төрөлхтөн **Антропоцен буюу Хүн төрөлхтөн эх дэлхийгээ өөрчилж буй үе** гэх геологийн тооллын шинэ эрин үед шилжсэний дохио болж байна.

200,000 гаруй жилийн урт удаан түүхэнд анх удаагаа **байгаль дэлхий хүмүүст биш, хүмүүс байгаль дэлхийдээ үзүүлэх нөлөөллөөрөө давамгайлж байна.**

Бидний үйлдлүүд, ялангуяа эд материалын ашиглалт болон хатуу түлшний хэрэглээнээс хамаарсан байдал маань уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг ихэсгэх, биологийн олон янз байдал алдагдах, далайн усны хүчиллэгийн түвшин нэмэгдэх, агаар, усны бохирдол, хөрсний доройтлыг улам бүр эрчимжүүлсээр байна. **Оршин амьдрахад маань амин чухал хэрэгтэй системүүдийн тэнцвэрийг** бид урьд өмнө байгаагүй хурд болон цар хүрээгээр алдагдуулж байна.

- Өлсгөлөнгийн түвшин нэмэгдсээр байна – Олон арван жил ахиц дэвшилтэй байсан хэдий ч 2019 оныг хүртэлх өнгөрсөн 5 жилийн хугацаанд өлсгөлөнд нэрвэгдсэн хүний тоо 60 саяар өсжээ (ХХААБ<sup>1</sup>).
- Сүүлийн 20 жилийн хугацаанд байгалийн аюулт үзэгдэлтэй холбоотой гамшгийн тоо 75 хувиар өсжээ. Эдгээр гамшгууд нийтдээ 4 тэрбум гаруй

---

<sup>1</sup> ХХААБ – Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага (FAO)

хүнд нөлөөлж, 1.23 сая хүний аминд хүрч, ойролцоогоор 3 их наяд долларын эдийн засгийн хохирол учруулсан байна (ГТЦШТ<sup>2</sup> 2020).

- Сүүлийн 50 жилийн хугацаанд дэлхийн зэрлэг амьтан ба ургамлын бараг 70% нь устсан байж болзошгүй.

**Манай гарагт учраад буй энэхүү дарамт нь олон оронд учирч буй сорилтуудын толин тусгал юм.** КОВИД-19-ийн нөлөөгөөр энэ бүхэн ил болсон нь санамсаргүй зүйл биш бөгөөд хүн төрөлхтөн зэрлэг ан амьтан хийгээд байгаль дэлхийдээ хайхрамжгүй хандаж ирсэнтэй холбоотой юм. Сүүлийн 30 жилд анх удаагаа дэлхий дахинаа хүний хөгжил буурах аюул тулгарч байгаа бөгөөд тэр дундаа эмзэг бүлгийн хүмүүст хамгийн хүндээр тусахаар байна.

Улс хоорондын болон дотоодын тэгш бус байдал нь дан ганц байгалийн аюулт өөрчлөлтийн үр дагавраас үүдэж буй бус, **шийдэл эрэх замд саад болдог эрх мэдэл хийгээд нөөц боломжийн тэнцвэргүй байдлаас** мөн үүдэн бий болж байна.

- Хар салхи, ой хээрийн түймэрт хэдийнээ талхлагдсан **хамгийн ядуу улс орнууд 2100 он гэхэд жилд 100 гаруй өдөр цаг агаарын онц аюулт үзэгдэлд өртөж болзошгүй байна.** Гэтэл уур амьсгалын өөрчлөлтөд илүү хэмжээгээр нөлөөлж буй чинээлэг орнуудын хувьд энэ үзүүлэлт 18 өдрөөр цөөн байж магадгүй юм (2020 оны Хүний Хөгжлийн Илтгэл).
- Хар салхинаас авахуулаад өлсгөлөн гэх мэт **гамшигт өртөмтгий байдал нь** байгалийн аюулт үзэгдэлтэй холбоотойгоос гадна **тэгш бус байдал хэдийнээ их байгаа улс орнуудад хамгийн өндөр** байгаа юм (2020 оны Хүний Хөгжлийн Илтгэл).
- **Дэлхийн халуун орны ойн ихэнх хэсгийг хамгаалан аж төрдөг уугуул иргэдийн аж амьдрал нь дэлхийн хамгийн баян хүмүүсийн 1%-ын ялгаруулсан нүүрстөрөгчийг тэнцвэржүүлэх хэмжээний эерэг үр нөлөөтэй** байдаг. Гэвч тэдгээр уугуул иргэд дэлхийн олон хэсэгт хүндрэл бэрхшээл, дарангуйлал, ялгаварлан гадуурхалд өртсөөр байна (2020 оны Хүний Хөгжлийн Илтгэл).

Хүмүүс *хийгээд* байгаль дэлхий маань биднийг өнөөгийн энэ цэгт хүргэсэн сонголтуудын маань нөлөөлөлд нэрвэгдэн зүдэрч байна. Хүн төрөлхтөн бид өөрсдийнхөө хамгийн аюултай дайсан нь болж хувирчээ. Гэхдээ **бидний цор ганц найдвар бол эргээд бид өөрсдөө билээ.**

Бидэнд *геологийн шинэ эрин үе* эхлүүлэх хүч чадал байгаа бол **өөрчлөлтийг сонгох хүч чадал** ч мөн байгаа гэсэн үг.

---

<sup>2</sup> ГТЦШТ – Гамшгийн Тархвар Судлалын Шинжилгээний Төв (CRED)

Уг өөрчлөлт нь хүний хөгжлийг ахиулахын тулд **хүн эсвэл ой моддын** аль нэгийг нь сонгох ёстой гэсэн санаанаас татгалзсанаар **эхлэх юм**. Аль нэгийг нь сонгож болохгүй, харин хоёуланг нь сонгох ёстой. Учир нь **байгаль дэлхийгээ золиослон байж бүтээсэн хүний хөгжил бол угтаа хүний хөгжил биш юм**.

Түүнчлэн, **тэгш бус байдлыг арилгаж, хүмүүсийг чадавхжуулснаар байгаль дэлхий, хүн хоёр хамтдаа цэцэглэн хөгждөг хүний хөгжлөөр дамжин уг өөрчлөлт хэрэгжих боломжтой юм**.

### **Өөрчлөлт**

Антропоценийн эрин үед асар их өөрчлөлт гарах боловч **ирээдүй хараахан нэгэн хэвэнд цутгасан мэт хөдөлшгүй байна гэсэн үг биш**.

Гэвч бид цаг алдалгүй зоригтой арга хэмжээ авах ёстой. Амьдарч, хөдөлмөрлөж, хамтран ажиллаж буй арга барилдаа асар их өөрчлөлтийг хийж, **хүний хөгжлийн ахиц дэвшлийн дараагийн шатыг** даван туулах замыг нээх ёстой.

**График дүрслэлийн ногоон хэсэг одоогоор хоосон байгаа буюу байгаль дэлхийдээ ноцтой ачаалал өгөхгүйгээр хүний хөгжлийн өндөр түвшинд хүрсэн улс орон хараахан байхгүй** энэ үед асар их өөрчлөлтийг хийх нь боломжгүй мэт санагдаж болох юм.

Гэхдээ бид зоригтойгоор урагшлах хэрэгтэй. **Тогтолцооны өөрчлөлт** нь ганц өдрийн дотор бий болохгүйгээс гадна, нуугдмал асуудлуудыг шийдвэрлэх цөөн хэдэн бодлогын хөшүүргийн үр дүнд ч бий болохгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Тодорхой байгаа ганц зүйл гэвэл хүн төрөлхтний одоогийн явж буй хөгжлийн замнал сүйрэлд хүргэх нь дамжиггүй гэсэн ойлголт юм.

Энэхүү шинэ эрин үед амжилттайгаар урагшилахын тулд улс орнуудын засгийн газрууд хувь хүмүүс, иргэний нийгэм, болон хувийн хэвшил зэрэг бүгдэд хүрч чадах манлайллын дэмжлэг үзүүлэх нь хамгийн чухал.

Энэхүү илтгэлд бодитой бөгөөд урт хугацааны өөрчлөлтийг бий болгоход шаардлагатай үндсэн гурван тулгуур баганыг тодорхойлсон юм. Тэдгээр нь: **байгалийн эсрэг биш, харин байгальтай хамтран ажиллах; урамшуулал хөшүүргийн тогтолцоог сайжруулах; мөн нийгмийн хэм хэмжээг өөрчлөх юм**.

- **Байгальд суурилсан шийдлүүд:** Байгаль бол бидний ахиц дэвшлийн тушаа бус, харин үндэс суурь нь юм. Бид байгалиас салангид биш, нэг хэсэг нь гэдгээ хүлээн зөвшөөрөх ёстой. Түүнчлэн байгалийн эсрэг бус, харин байгальтай зохицсон шийдлүүд л хүмүүс болон дэлхий гараг цэцэглэн хөгжихөд тусалж чадна гэдгийг ойлгох ёстой.

**Жишээ:** Энэхүү илтгэлд хөдөө аж ахуй, зам тээврээс авхуулаад аялал жуучлал, эрүүл мэнд, санхүү хүртэл олон салбарыг өөрчилж, **2030 он гэхэд дэлхийн дулаарлын өсөлтийг цельсийн 2 хэмээс бага** байлгахад шаардлагатай **нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах зорилтын 37 хувийг хангаж чадах байгальд суурилсан 20 шийдлийг** тодорхойлсон байгаа.

Ой моддыг нөхөн сэргээснээр нүүрстөрөгчийг шингээж, биологийн олон янз байдлыг хамгаалдаг. Мөн ойд амьдардаг хүмүүсийг хүнсний тогтвортой эх үүсвэрээр хангахын зэрэгцээ суурьшлаас хол амьдарч байгаа хүмүүсийг хэрэгцээт цэвэр усаар нь хангах бороо хурыг үүсгэдэг.

- **Урамшуулал хөшүүрэг:** Бидний шийдвэр гаргалтад нөлөөлдөг хөшүүрэг болон **зохицуулалтууд** нь байгаль дэлхийн хохирлоос сэргийлэх бус, харин ч дэмжих тохиолдол дэндүү их байна.

**Жишээ:** 2019 онд л гэхэд түлшний татаасад зориулж дэлхий даяар 300 гаруй тэрбум доллар зарцуулсан байна. Ингэснээр сэргээгдэх эрчим хүчний өрсөлдөх чадварыг сулруулж байна. **Эдгээр татаасыг байхгүй болгосноор нүүрстөрөгчийн ялгарлыг 25 гаруй хувиар бууруулж болно.**

Нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулж, хүлцэх хэмжээнд нь барих цогц шийдлийн нэг чухал бүрэлдэхүүн нь **нүүрстөрөгчийн татвар** юм.

**Жишээ:** Сэргээгдэх эрчим хүч шатах ашигт малтмалаас хямд өртөгтэй болсноор цэвэр эрчим хүчээр тэжээгддэг ирээдүй шинжлэх ухааны уран зөгнөл биш, харин ёс зүйтэй, санхүүгийн үр ашигтай, бодит сонголт болно. **Сэргээгдэх эрчим хүчинд хөрөнгө оруулах нь** ард түмэнд эрх мэдлийг өгөх, эрчим хүчний эх үүсвэрийг ардчилсан болгох (бодит) арга зам юм.

**Жишээ:** Парисын Хэлэлцээрийг хэрэгжүүлснээр дэлхийн хамгийн ядуу орнуудын **цаг агаарын онц аюулт үзэгдэлд өртөх** өдрүүдийн тоо нэмэгдэх явдлыг хоёр дахин багасгаж чадна гэж 2020 оны Хүний Хөгжлийн Илтгэл үзэж байна.

Улс үндэстнүүдийг хариуцлагатай байлгаж, итгэлцэл хийгээд уялдааг нэмэгдүүлэх **олон улсын өнөөгийн гэрээ, хэлэлцээр, зохицуулалтуудыг бэхжүүлэх нь** бидний өмнө буй том зорилгыг ажил хэрэг болгох гол алхам юм.

- **Нийгмийн хэм хэмжээ:** Хүн бүрд өөрийн гэсэн үүрэг бий. Гэхдээ хүмүүст үүргээ биелүүлэх урам зориг өгч, үйлдэл хийх боломж олгох хэрэгтэй. Судалгаанаас үзэхэд хүмүүсийн 80 хувь нь байгаль дэлхийгээ хамгаалах нь

чухал гэж боддог ч, 50 хүрэхгүй хувь нь ямар нэгэн үйлдэл хийдэг байна. Хүмүүсийн зан үйлд эргэн тойрны хүмүүс нь асар их нөлөөлдөг.

*Жишээ:* Нийгмийн шинэ хэм хэмжээ асар богино хугацаанд тогтож болно. Энэ жилийн эхэнд гэхэд өмнө нь хэзээ ч амны хаалт зүүнэ гэж бодож байгаагүй олон сая хүн өнөөдөр гэрээс гарах бүрдээ амны хаалт зүүдэг болсон нь үүний баталгаа юм.

Сургуулиудын хичээлийн хөтөлбөрт тогтвортой байдлын тухай чанартай боловсролыг нягт шигтгэж өгөх хэрэгтэй. Гараг дэлхий болон байгаль орчны үнэ цэнийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд насан туршийн боловсрол эзэмших боломжууд мөн амин чухал үүрэгтэй.

### **Шинэ хэмжүүр**

Антропоценийн шинэ эрин үе хүмүүс биднээс байгаль дэлхийдээ өгч буй дарамтыг үгүйсгэдэггүй, нуудаггүй хүний хөгжлийн шинэ хэмжүүр шаардаж байна.

Эх дэлхийдээ өгч буй дарамтыг тооцсон Хүний хөгжлийн индекс (ДДТХХИ) нь улс үндэстнүүдийн ахиц дэвшлээ үнэлбэл зохих аргачлалыг шинэчлэх болно. Хүний хөгжлийн ахиц дэвшлийг тэнцвэржүүлэх шинэ босго тогтоох **ДДТХХИ нь улс үндэстэн тус бүрийн нүүрстөрөгчийн ялгаруулалт, материалын хэрэглээ гэсэн хоёр талбар дахь байгаль дэлхийдээ үзүүлж ачааллыг, нэг хүнд ногдох байдлаар Хүний хөгжлийн үндсэн индекстэй нь уялдуулан тооцдог.**

Хүний хөгжлөөр доогуур жагсдаг улс орнуудын хувьд энэхүү шинэ индексээс үүдэн гарах хүний хөгжлийн эрэмбийн өөрчлөлт ерөнхийдөө бага байна. Өндөр эсвэл маш өндөр хүний хөгжилтэй улс орнуудын хувьд индексийн утгад гарах зөрүү нэлээн сөрөг байгаа ба энэ нь тэдний хөгжлийн замнал гараг дэлхийд хэрхэн сөргөөр нөлөөлж байгааг тод томруунаар харуулж байгаа юм.